


**БАТЛАВ.
САНГИЙН САЙД**



З.МЭНДСАЙХАН

**БАТЛАВ.
МОНГОЛ УЛСЫН
ТЭРГҮҮН ШАДАР
САЙД БӨГӨӨД ЭДИЙН
ЗАСАГ, ХӨГЖЛИЙН
САЙД**



Ж.ЭНХБАЯР

**БАТЛАВ.
ЭРЧИМ ХҮЧНИЙ
САЙД**



Б.НАЙДАЛАА

**БАТЛАВ.
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД**



Б.БАТЦЭЦЭГ

**БАТЛАВ.
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
САЙД**



С.АМАРСАЙХАН

2026 оны 06 сарын 19-ны өдөр

**МОНГОЛ УЛС, ОЛОН УЛСЫН СЭРГЭЭН БОСГОЛТ, ХӨГЖЛИЙН БАНК
ХООРОНДЫН ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**Нэг.Хууль тогтоомжийн төсөл боловсруулах болсон үндэслэл,
шаардлага**

Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны 2026 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн хуралдаан, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо болон Төсвийн байнгын хорооны 2026 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн хамтарсан хуралдааны санал, дүгнэлт, Монгол Улсын Ерөнхий сайдын 2026 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 88 дугаар захирамжийг тус тус үндэслэн Монгол Улс, Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын “Эрчим хүч-4” төслийн

зээлийн хэлэлцээрт Сангийн сайд З.Мэндсайхан 2026 оны 05 дугаар сарын 08-ны өдөр гарын үсэг зурсан.

Тус хэлэлцээр нь Олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалтад заасны дагуу гадаад улс, олон улсын байгууллагаас авах зээлийн ерөнхий нөхцөлийн тухай гэрээ тул Улсын Их Хурлаар заавал соёрхон батлуулах шаардлагатай юм.

Хоёр.Хууль тогтоомжийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөл нь 1 зүйлтэй байх бөгөөд тус зүйлд Монгол Улс, Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын байгуулсан “Эрчим хүч-4” төслийн зээлийн хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлахаар тусгасан.

Гурав.Хууль тогтоомж батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Монгол Улс, Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийг баталснаар нийгэм, эдийн засаг, хууль зүйн аливаа сөрөг үр дагавар гарахгүй бөгөөд Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банкны зээлийн эх үүсвэрээр “Эрчим хүч-4” төслийн барилга угсралтын багц ажил болон магадалшгүй бусад ажилд шаардагдах зардлыг санхүүжүүлэх боломжтой болно.

Дөрөв.Хууль тогтоомжийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Олон Улсын гэрээний тухай, Хууль тогтоомжийн тухай болон бусад хууль тогтоомжид нийцүүлэх бөгөөд хуулийн төсөлтэй уялдуулан шинээр боловсруулах, нэмэлт өөрчлөлт оруулах хүчингүй болгох хууль байхгүй болно.